



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/572

Зуунмод

Зардал гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээ, харуул хамгаалалт, постуудад 9 сард шаардлагатай зардлыг хавсралтаар 8,487,500 (найман сая дөрвөн зуун наян долоон мянга таван зуу)-төгрөгөөр баталсугай.

2. Зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР